МОНГОЛ ОРНЫ ЖИЖИГ ХОТ СУУРИН ГАЗРЫН ХҮНСНИЙ БАТАЛГААТ БАЙДАЛ БА АМЬЖИРГАА

Аймгийн Төвийн Хүнсний Баталгаат Байдлын Судалгааны Үр дүн

Товч тайлан - 2008 оны 03 сар

USDA United States Department of Agriculture

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC

MercyCorps

Be the change

МОНГОЛ УЛСЫН ХОТ СУУРИН ГАЗРУУД ДАХЬ ХҮНСНИЙ БАТАЛГААТ БАЙДАЛ, АМЬЖИРГАА

Аймгийн төвүүдийн хүнсний баталгаат байдлын үнэлгээний тайлан

Нэгтгэсэн тайлан

Крис Хилбрунер
Хүнсний баталгаат байдлын зөвлөх

Меган Мерфи
Mickey Leland International Hunger
байгууллагын тэтгэлэгт ажилтан

МЕРСИ КОР МОНГОЛ
Энх тайваны өргөн чөлөө- 24, Баянзүрх дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-1146-0967

2008 оны 3 дугаар сар

Танилцуулга

Энэхүү тайланд Аймгийн төвүүдийн хүнсний баталгаат байдлын үнэлгээнээс гарсан үр дүнг нэгтгэсэн бөгөөд хүнсний баталгаат байдал алдагдаж буйг илрүүлэх, түүний шинж тэмдэгүүд болон хүнсний баталгаат байдлын алдагдлыг тогтоох үзүүлэлтүүдийг онцгойлон судалсан юм. Үнэлгээний үр дүнд анх удаа Монгол орны аймгийн төвд оршин сууж буй иргэдийн хүнсний баталгаат байдлын талаарх тодорхой туршилтын, практик нотолгоог судлан гаргасан билээ. Хэдий статистик үзүүлэлтээр Монгол улсыг бүхэлд нь хамхар боломжгүй ч, Баруун-Урт, Арвайхээр, Улаангом болон Ховд хотуудад явагдсан судалгааны үр дүн нь өөр бусад аймгийн төвүүдийн нөхцөл байдлыг ч тусган харуулах боломжтой юм.

Үнэлгээний явцад хамгийн их хүндрэлтэй тулгарсан асуудал нь хүнсний баталгаат байдал хангамж, олдоцын асуудалтай хамааралтай байв. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн гуравны нэг нь хүнсний баталгаа нь алдагдсан, тэдний 25% нь хүнсний баталгаа их хэмжээгээр алдагдсан нөхцөлд амьдарч байна. Үүн дээр нэмээд хүнсний баталгаат байдлын улирлын загварын талаар цуглуулсан мэдээлэл нь хүнсний хангамж нийлүүлэлт, ажлын байрны хэмжээ огцом буурдаг хаврын улиралд нөхцөл байдалд ихээхэн хүндрэлтэй учруулдаг болохыг нээн харуулсан юм.

Энэхүү судалгааны дүн нь цаашид Монгол улсад хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд ихээхэн ач холбогдолтой бөгөөд аймгийн төвүүдийн хүнсний баталгаат байдлыг хангах чиглэлээр төлөвлөж буй цаашдын үйл ажиллагаа нь одоо хэрэглэгдэж буй хандлагууд болон шинэ санаачлагуудыг үр дүнтйэгээр хослуулан орон нутгийн ажилгүйдэл, ажиллах хүчний чадамж, иргэд хуримтлал үүсгэх боломжгүй байдал, зөвхөн хэрэглээгээ хангах зориулалтаар зээл авах, үүний зэрэгцээ хүнсний маркетингийн үр дүн муутай тогтолцоо болон хүүхдийн тэжээлийн дутагдал зэрэг олон асуудлыг шийдэхэд чиглэгдэх шаардлагатайг цохон тэмдэглэж байна .

Үнэлгээний үр дүн, үр дүнгийн хүснэгтүүд, үнэлгээний аргачлалуудын талаарх бүрэн хэмжээний мэдээллийг, илүү гүнзгийрүүлсэн эцсийн тайлан хэлбэрээр Мерси Короос хүсэмжлэн авч болох бөгөөд www.mercycorps.org.mn вебсайтаас мөн татан авч болно.

Судалгааны үндэслэл

Хүнсний баталгаат байдлыг “бүх хүмүүс, бүх цаг хугацааны туршид тэдний тэжээлийн хэрэгцээ болон хүнсний эрхэм чанарт нийцэхүйц, идэвхтэй эрүүл амьдралаар амьдрахад шаардагдах хангалттай, эрүүл, тэжээллэг хоол хүнс хэрэглэх явдал”[1] хэмээн албан ёсоор тодорхойлдог. Энэхүү олон салаа утга бүхий тодорхойлолтыг тоон үзүүлэлтээр илэрхийлэхэд хүндрэлтэй байдгийн улмаас хүнсний баталгаат байдлыг гол төлөв хэмжихэд хялбар 4 бүрэлдхүүн хэсэгт хуваадаг нь хүнсний хангамж, олдоц, хэрэглээ болон тогтвортой байдал зэрэг болно.

Ихэнх тохиолдолд хүнсний баталгаат байдлын хөтөлбөрүүд нь хүн амын дийлэнх хэсэг нь газар тариаланг, амьжиргаагаа хангах хэлбэрийн аж ахуй эрхлэн амьдардаг хөдөө, орон нутгуудад төвлөрдөг юм. Хэдий байдал ийм боловч Монгол улсын хувьд хөдөө орон нутгийн өрхүүдийн ихэнх хувь нь хүнсний баталгаат байдлын хувьд зохих түвшинд байна. Мал аж ахуй дээр суурилсан хөдөө аж ахуй нь хөдөөгийн айл өрхүүдийг их хэмжээний мах, сүү, цагаан идээгээр хангаж байдгаас гадна албан бусаар тогтсон баталгаат байдлын сүлжээ ч

[1] Дэлхийн хүнсний баталгаат байдлын Ромын тунхаглал (1996) Хүнсний асуудлаарх дэлхийн дээд хэмжээний уулзалт. Ром хот, Итали улс

ихээхэн тогтвортой, бат бөх байгаа ажээ (ХХААБ/НҮБХС/НҮБХХ 2007). Харин Монгол улсын хүн амын дийлэнх (60%) хэсэг амьдран суудаг, цаашид ч хүн амын өсөлт өндөртэй байгаа хот, суурин газруудад хүнсний баталгаат байдал алдагдан, хамгийн ноцтой нөхцөлд хүрээд байна хэмээн тооцож байна (ҮСГ 2004). Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сан болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хийсэн судалгаагаар хот суурин газрын (Улаанбаатар хот болон аймгийн төвүүд) хүн амын 30 орчим хувь нь хүнсний баталгаат байдал алдагдсан нөхцөлд амьдарч буйг тогтоожээ. Хүнсний олдоцын улирлын хэлбэлзэл, хот суурин газрын амьжиргааны өндөр өртөг болон ажилгүйдэл зэрэг нь суурин газрын хүн амын хүнсний баталгаат байдал алдагдаж буйг харуулах гол үзүүлэлтүүд байлаа (2007).

Гэхдээ дээрх дүгнэлт нь ихэвчлэн орлого, ядуурлын холбогдолтой мэдээллийг шууд хөрвүүлсэн учраас хүнсний баталгаат байдлын нөхцөл байдалтай бүрэн нийцэхгүй байгаа юм. Өрхийн түвшинд хүнсний баталгаат байдал алдагдсан болохыг тодорхойлох үзүүлэлтүүдийн талаарх мэдээллүүд ихээхэн дутуу дулимаг, цуглуулах боломжгүй байлаа. Энэ нь Улаанбаатараас бусад суурин газруудад хэрэгжих боломж нь бүр тааруу байгаа билээ. Эцэст нь хэлэхэд Өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдал, хангамжийн харьцаа зэрэг шинээр гарсан хэмжүүрийг Монгол улсад тохируулан хэрэгжүүлэхээр хараахан шинэчлэн боловсруулаагүй байгаа ажээ.

Судалгааны зорилго болон хамрах хүрээ

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь “Аймгийн төвүүдэд хүнсний баталгаат байдал хангагдсан уу?” хэмээх асуултад бүрэн хариулт авах зорилготой байсан юм. Илүү нарийвчлан авч үзвэл энэхүү судалгаа нь дараах чиглэлд гүнзгийрүүлэн судалсан юм. Үүнд:

- Аймгийн төвийн хэмжээнд хүнсний олдоцод ямар саад бэрхшээл тулгарч байна вэ?
- Аймгийн төвийн өрхийн хэмжээнд хүнсний баталгаат байдал хэр хэмжээнд, ямар түвшинд алдагдаад байна вэ?
- Цаашид тодорхойлох болон хөтөлбөрийн зүгээс үйл ажиллагааг чиглүүлэх хүнсний баталгаат байдал алдагдсан өрхүүдийн голлох шинж тэмдэгүүд ямар вэ?
- Ямар хүчин зүйлсүүд өрхийн түвшний хүнсний баталгаат байдлыг сайжруулах болон муутгаж байна вэ?

Мерси Кор Монгол

Мерси Кор нь Монгол улсад 1999 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байна. Одоогоор Мерси Кор нь орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх болон иргэний нийгмийг бэхжүүлэх зорилго бүхий 5 хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд эдгээрт Говийн санаачлага, Хөдөөгийн агри-бизнесийг дэмжих хөтөлбөр, Говийн бэлчээр, Сургалт, нөлөөлөл ба хамтын ажиллагааны сүлжээ буюу ТАН хөтөлбөр болон Баруун бүсийн эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүд багтаж байна.

Хот суурин газрын хүн амын хүнсний баталгаат байдлын чиглэлээр хийж буй Мерси Корын үйл ажиллагаа нь хоёр үндсэн боломжийг түлхүү ашиглан давуу талуудыг бий болгох зорилготой. Нэгдүгээрт аймгийн төвийн хүнсний захууд, суурин газрын өрхийн зарлага болон хэрэглээний загвар зэргийн талаарх илүү нарийвчилсан мэдээллийг одоо хэрэгжүүлж буй агри-бизнесийн хөгжлийн санаачлагуудын хүрээнд ханган өгөх, тухайн хөтөлбөрүүдийг хэрэглэгчийн болон бизнес эрхлэгчдийн эрэлтэд илүү үр дүнтэйгээр хандах боломжийг олгох явдал юм. Хоёрдугаарт суурин газрын хүнсний баталгаат байдал, түүний үзүүлэлтүүдийг сайтар судалснаар цаашид хэрэгжүүлж болох хөтөлбөрүүд, түншлэлийн гарааны шавыг тавих, ялангуяа хүнсний баталгаат байдал, архаг хоол тэжээлийн дутагдал

(Монгол улсад өргөн дэлгэрсэн тухайн төрлийн) болон эдийн засгийн хөгжлийн хоорондын чухал уялдааг харилцан хамруулах явдал юм.

Арга зүй

Энэхүү үнэлгээг урьдчилан сонгон авсан дөрвөн аймаг буюу Баруун-Урт, Арвайхээр, Улаангом болон Ховд хотуудад гүйцэтгэлээ. Үнэлгээний явцад судалгааны хоёр аргачлалыг түлхүү ашигласан бөгөөд хүнсний хангамжын талаарх чанарын судалгаа болон хүнсний баталгаат байдал, үүний үзүүлэлтүүдийн талаарх өрхийн түвшинд судлан мэдээлэл цуглуулсан тоон судалгааг хийж гүйцэтгэсэн. Зах зээлийн судалгааны хүрээнд орон нутгийн бизнес эрхлэгчидтэй нийт 73 удаагийн ярилцлагыг зохион явуулсан. Хэдийгээр энэхүү түүвэрчлэл нь санамсаргүй бус байсан ч гэсэн хамрагдах бизнесийн төлөөллийг эрхлэж буй бизнесийн төрөл, хэмжээ болон байрлалаар нь аль болох өргөн хүрээг хамруулан сонгон авахаар хичээсэн болно.

Өрхийн судалгааны хувьд, энгийн давхарга бүхий, санамсаргүй түүвэрлэлтийг ашиглан үүгээр дамжуулан сонгогдсон аймгуудын хоорондын харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэсэн. Хэдийгээр энэхүү мэдээлэл нь Монгол улсын бусад аймгуудын хэмжээний өргөн хүрээний мэдээллийг харуулж болох ч үндсэндээ зөвхөн тухайн сонгон авсан аймгуудын хувьд бүрэн статистик төлөөлөлтэй юм. Судалгааны хүрээнд нийт дүнгээр 4 аймгийн төвийн 872 өрхөөр орсоноос 663 өрхийг бүрэн хэмжээгээр судалгаанд хамруулсан нь нийт өрхийн 76% болж байна.

Үр дүн

<u>Хүнсний бүтээгдэхүүний олдоц</u>

Судалгаанд хамрагдсан 4 аймгийн төвийн нийт 73 бизнес эрхлэгчтэй уулзан ярилцага хийлээ. Эдгээр хүмүүс нь хүнсний чиглэлийн бизнесийн олон салбарыг (Хүснэгт 1) төлөөлж байсан бөгөөд тэд тухайн салбартаа өөрийн гэсэн гүйцэтгэх үүрэг бүхий бизнесүүд юм (Хүснэгт 2). Судалгаанд хамгийн ихээр хамрагдсан бизнесийн төрөлд махны салбар багтсан бөгөөд үүний дараагаар гурил болон сүү, цагаан идээний үйлдвэрлэл байлаа. Хүнсний ихэнх бизнес нь худалдааны чиглэлээр байсан бол арилжааны болон болосвруулах чиглэл ч мөн өргөнөөр хамрагдсан юм. Аймгийн төвийн хувьд одоогоор хүнсний үйлдвэрлэл маш бага хэмжээгээр явагдаж байгаа болно.

Хүснэгт 1: Зах зээлийн судалгааны түүвэрлэлт-хүнсний сектороор

Тодорхой хүнсний салбарт ажилладаг бизнес эрхлэгчид				
Мах	*Ногоо, жимс*	*Сүү, цагаан идээ*	*Гурил, гурилан бүтээгдэхүүн, талх, будаа*	*Бусад боловсруулсан хүнс*
37	**28**	**32**	**33**	**22**

Хүснэгт 2: Зах зээлийн судалгааны түүвэрлэлт- гүйцэтгэх үүргээр

Хүнсий төрөл	**Өртгийн сүлжээнд эзлэх байр суурь**			
	Үйлдвэрлэгч	*Боловсруулагч*	*Худалдагч*	*Арилжаа эрхлэгч*
Мах	0	11	31	9
Ногоо, жимс	8	3	27	6
Сүү, цагаан идээ	3	7	29	6
Гурил, талх, будаа	0	9	27	10
Бусад боловсруулсан хүнс	11	31	22	6

Зах зээлийн бүтэц, салбарын бүтээгдэхүүний олдоц болон үнэ ханш

Зах зээлийн судалгааны явцад хүнсний салбарын 5 гол төрлийг тогтоон судалсан бөгөөд үүнд мах, сүү/цагаан идээ, жимс/ногоо, гурил болон бусад боловсруулсан хүнс зэрэг багтсан юм. Доорх бүлэгт тухайн төрлийн хүнсний зах зээлийн бүтэц болон одоогийн үнийг аймаг тус бүрээр нь тусгасан болно.

Мах

Аймгийн төвийн хэмжээнд хамгийн олдоц ихтэй мах нь үхэр, хонины мах байлаа. Хэдийгээр орон нутагт тэмээ болон адууны мах худалдаалагдаж байгаа ч нийлүүлэлт нь тэр бүр их хэмжээтэй байдаггүй ажээ. Бага хэмжээний загасан бүтээгдэхүүнийг аймгийн төвийн зах дээр зардаг байна. Аймгийн төвийн иргэдийн хувьд мах худалдан авах хамгийн гол суваг нь хөдөөгийн сумд юм. Маш бага хэмжэний махыг Улаанбаатараас таээвэрлэн ирж худалдаалж байна. Харин шинэ махыг орон нутгийн захууд болон жижиг хэмжээний хүнсний дэлгүүрүүдээр дамжуулан зардаг юм.

Орон нутгийн мал нядалгааны цэгүүдэд мал нядлах, мөн бага хэмжээгээр хиам үйлдвэрлэх/мах нөөшлөх гэсэн хоёр төрлийн боловсруулах үйл явц аймгийн төвийн түвшинд явагдаж байна. Албан ёсоор аймгийн төвийн захуудаар зарагдаж байгаа бүх мах нь мал эмнэлгийн шинжилгээнд хамрагдах ёстой бөгөөд мал эмнэлгийн үйлчилгээ нь зөвхөн нядалгааны цэгүүд дээр ажилладаг байна. Гэхдээ бодит байдал дээр зөвхөн нийслэл Улаанбаатар хотод худалдаалахаар авч яваа маханд л энэхүү шалгалт хамаарч байна. Хиам үйлдвэрлэл болон мах нөөцлөх нь ихээхэн бага хэмжээтэй хэдий ч өөрийн түгээлтийн сүлжээний хувьд нилээд өргөжсөн байх магадлалтай байна.

Махны үнэ аймгийн төвийн захууд дээр нэг килограм нь 800-2 150 төгрөгийн (0.68-1.82 ам доллар) хооронд хэлбэлзэж байна. Боловсруулсан махан бүтээгдэхүүний үнэ ханшийн хувьд килограм тус бүр нь 900-5 500 төгрөгийн (0.76-4.62 ам доллар) ханштай байна. Харин мах, махан бүтээгдэхүүний олдоц нь аймгийн төвүүдэд тухайн улирлаас ихээхэн хамааралтай бөгөөд намрын улиралд махны нийлүүлэлт нэмэгдэн, тарга хүч сайн авсан малын махыг аймгийн төвийн иргэд худалдан авч өвлийн хэрэгцээндээ зориулан нөөцөлдөг байна. Дээрх шалтгааны улмаас энэхүү үнэлгээний хүрээнд цуглуусан үнийн мэдээлэл нь тухайн жилийн хамгийн доод үнийн түвшинд хамаарах бөгөөд дэлхийн хэмжээгээр хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, мөнгөний ханш уналт үүсч байгаа үед энэхүү дүгнэлт нь зарим талаар ташаа байж болох юм. Харин хаврын улиралд махны нийлүүлэлт багасаж, үнийн хувьд өсөж ирдэг ба энэ үеэр мал таргалаагүй байх, малд төллөх үе голлон таардаг учраас энэ байдлыг үүсгэдэг байна. Зун ч гэсэн махны хангамжид өөрийн гэсэн асуудалд байдаг нь мах хадгалах зоорь, хөргөлттэй агуулах байдаггүйн улмаас махны чанар муудах зэрэг явдал гардагаас үүддэг ажээ.

Хүнсний ногоо, жимс

Төмс, сонгино, байцаа болон лууван зэрэг өргөн хэрэглээний хүнсний ногоо нь аймгийн төвүүдэд хамгийн ихээр нийлүүлэгдэж байна. Аймгийн төвд зарагдаж байгаа ногооны эх үүсвэрийн хувьд орон нутгийн үйлдвэрлэгчид болон Хятадаас ногоо импортлон оруулж ирэгчид гэсэн хоёр бүлэгт хуваагдах бөгөөд импортын хувьд Улаанбаатар хотоор дамжих эсвэл шууд импортлох замаар яагддаг байна. Алим, мандарин зэрэг жимсний хувьд нийлүүлэлт ихээхэн хязгаарлалттай бөгөөд бараг бүх бүтээгдэхүүнийг 100% импортоор авч байна. Дарсан өргөст хэмхээс бусад тохиолдолд жимсний боловсруулалт огт хийгдэхгүй байна. Жимс, хүнсний ногооны олдоц нь тоо хэмжээ болон чанарын хувьд ч ихээхэн муу

байдагаараа ялгарч байсан ба ялангуяа өвөл, хаврын улиралд үнийн асөлт маш өндөр байдаг ажээ.

Дунджаар нэг килограм төмсний үнэ 428 төгрөг (0.36 ам доллар), цэцэгт байцаа 3 000 төгрөг (2.54 ам доллар) байна. Жимсний үнэ нь нэг килограм алим 1 180 төгрөг (1.00 ам доллар) бол чавга болон усан үзэм 2 500 төгрөг (2.12 ам доллар) байна. Үнийн хувьд баруун аймгуудад харьцангуй өндөр байсан нь тээврийн зардал өндөр байдгаас хамаарсан байж болох юм.

Сүү, цагаан идээ

Аймгийн төвүүдэд нийлүүлэгдэж байгаа сүүн бүтээгдэхүүний тоонд сүү, цөцгийн тос болон зарим талаар бага зэрэг ховордуу ч гэсэн өндөг зэрэг бүтээгдэхүүн багтаж байна. Тараг, ааруул болон өөр бусад уламжлалт цагаан идээг мөн зах зээл дээрээс худалдан авч болно. Зун болон намрын эхэн саруудад орон нутгийн үйлдвэрлэгчид (аймгийн төвийн болон сумдын) ихээхэн хэмжээний сүү, цөцгийн тос болон бусад бүтээгдэхүүнийг үйдвэрлэж байна. Гэсэн ч өвөл, хаврын улиралд орон нутагт боловсруулсан цагаан идээний олдоц хомсдож байгаагын гол шалтгаан нь хадгалах зориулалтын хэрэгсэлгүй байгаагаас хамаарч байна. Харин энэ үеэр хайрцагтай болон хуурай сүүг Хятадаас импортлон оруулж ирж байгаа ба үүний ихэнх хувь нь Улаанбаатар хотоор дамжин нийлүүлэгдэж байна. Зориулалтын хадгалах байгууламж дутагдалтай байгаа нь зуны улиралд ч мөн нөлөөлж сүү гашлах, чанар муудах зэрэг асуудлыг үүсгэж байна. Судалгаанд хамрагдсан аймгийн төвүүдээр өндөгний хангамж доголдолтой байсан ч зоогийн газар болон нарийн боов үйлдвэрлэгчдийн хувьд өндөг маш өндөр эрэлттэй бүтээгдэхүүн байсан болно. Ааруул зэрэг уламжлалт цагаан идээний үйлдвэрлэлээс бусдаар аймгийн төвүүдэд сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл ихээхэн хязгаарлагдмал байна.

Сүүн бүтээгдэхүүний үнэ нэг килограм нь 600-5 500 төгрөгийн (0.51-4.62 ам доллар) хооронд хэлбэлзэж байна. Жилийн бусад үетэй харьцуулахад үнийн хувьд энэхүү үнэ нь дундаж түвшинд байгаа юм. Зах зээлийн үнэ хамгийн бага байх үе нь зуны сүүл, намрын эхэн сар бол хамгийн өндөр үнэ нь хаврын улиралд ажиглагддаг байна. Өндөгний дундаж үнэ нэг ширхэг нь 240 төгрөг (0.20 ам доллар) байна. Жилийн бусад үед (11-12 дугаар сар) үнэ өндөр байдаг бөгөөд орон нутгийн бизнес эрхлэгчдийн хэлсэнээр өвлийн эхний саруудад гуужилтын улмаас тахиа өндөглөхөө больдог ажээ. Баруун-Урт болон Арвайхээр хотуудтай харьцуулахад баруун бүсэд сүүн бүтээгдэхүүний олдоц тааруу, илүү өндөр үнэтэй байна.

Гурил, гурилан бүтээгдэхүүн, талх, будаа

Судалгаанд хамрагдсан бүх аймгийн зах зээл дээр гурилын нийлүүлэлт сайн байсан ба нийлүүлэлт нь улирлаас хамааран хэлбэлзэх байдал бараг үгүй байгаа нь ажиглагдсан. Гэхдээ аль ч аймгийн төвд гурилын үйлдвэр болон газар тариалан эрхлэж буй бизнес байсангүй. Харин гурилын нийлүүлэлтийн хамгийн гол суваг нь Улаанбаатар хот бөгөөд мөн Орос болон Хятад улсуудаас шууд импортлон оруулж ирдэг байна. Будааны хувьд 100% импортоос хамааралтай байна. Гурилыг ихэвчлэн аймгийн төвийн задгай захуудаар болон шууд гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарт борлуулж байна. Гурил боловсруулагчдын хувьд нарийн боов үйлдвэрлэгчид болон хэрчсэн гурил, гоймон үйлдвэрлэгчид зонхилох бөгөөд эдгээр нь аймгийн төвүүд дээр хамгийн өндөр хөгжсөн хүнсний чиглэлийн бизнесийн салбарууд болж зарим нь өөрийн сүлжээг өөр бусад аймгуудад ч оруулж амжсан байна.

Гурилын үнэ нь килограм тус бүр нь 540-1 050 төгрөгийн (0.46-0.89 ам доллар) хооронд байх ба өнгөрсөн жилийн дэлхийн хэмжээний гурилын хомсдол, шатахууны үнийн өсөлтөөс хамааран огцом өсжээ. Гурил нь ихэвчлэн аймгийн төвийн задгай захуудаар их хэмжээгээр

арилжаалагдаг бөгөөд үүний шалтгааныг дэлгүүрийн эзэд бага хэмжээгээр жижиглэн худалдаалах нь ашиг багатай байдагт оршдог хэмээн тайлбарлаж байлаа.

Бусад төрлийн боловсруулсан хүнсний зүйлс

Давс, элсэн чихэр, тос болон лаазалсан бүтээгдэхүүн зэрэг бусад боловсруулсан хүнсний зүйлс зэрэг бараа зах зээл байгаа ч эдгээрийг тухайн аймагт боловсруулан үйлдвэрлэдэггүй байна. Энэ төрлийн хүнсний зүйлсийг ихэвчлэн Улаанбаатар тээвэрлэн авчирлдаг бөгөөд бага хэмжээгээр Хятад болон Орос улсуудаас оруулж ирдэг ажээ. Дээрх бүтээгдэхүүнүүдийн хувьд зах зээл дээрх олдоц маш сайн байсан бөгөөд ямар нэгэн байдлаар улирлаас хамааран хэлбэлзэх тохиолдол ажиглагдаагүй болно. Нийт дөрвөн аймгийн хэмжээнд элсэн чихрийн үнэ нэг килограм нь 950 төгрөг (0.81 ам доллар) байлаа. Ургамлын тосны дундаж үнэ нэг литр нь (Зөвхөн Улаангом болон Ховд хотуудад мэдээлэл цуглуусанаар) 2 777 төгрөг (2.35 ам доллар) байлаа.

Хүнсний бүтээгдэхүүний олдоцод тулгарч буй саад тотгор

Орон нутгийн хүнс үйлдвэрлэгчидтэй хийсэн ярилцлагаар тулгараад байгаа хэд хэдэн саад тотгорыг тодорхойлон гаргасан. Хамгийн чухал нь, сүү/цагаан идээ, мах, жимс/ногооны салбар нь ихээхэн хэмжээгээр улирлын хамааралтай байж зуны сүүл сараас өвлийн эхэн сар хүртэл олдоц хамгийн сайтай, харин хавар хамгийн их хомсдолтой байдаг ажээ. Тоо болон чанарын хувьд ихээхэн хэмжээгээр бууралттай байхын хажуугаар энэ хомсдолын үеэр үнэ өсдөг нь хэвийн үзэгдэл байна. Энэхүү хэлбэлзлийн хамгийн гол шалтгаан нь улирлын чанартай үйлдвэрлэлийн загвар, аймгийн төвүүдэд хүнсний бүтээгдэхүүн хадгалах боломж тааруу байх болон өвлийн улиралд маш их хүндрэл үүсгэдэг дэд бүтэц сул хөгжсөн байдал зэрэг багтаж байна.

Тээвэр болон дэд бүтэцтэй хамаарах хэд хэдэн өөр бусад асуудлууд мөн тогтоогдсон. Юуны өмнө ихэнх бизнес эрхлэгчид Улаанбаатар хот болон бусад том худалдааны бүс нутгууд орохын тулд нийтийн унаагаар явах эсвэл нийлж машин хөлсөлж бараагаа татдаг байна. Харин энэхүү нийтийн тээврийн болон хамтран унаа хөлслөх систем нь үр дүн муутай, зохион байгуулалт муутай байлаа. Үүний улмаас хүнсний бараа нийлүүлэх үйлчилгээний хөлс нь урьдчилан таамаглах бололцоогүй тул бизнес эрхлэгчид өөрсдийн бизнесийг зохистойгоор төлөвлөхөд хүндрэл учруулдаг ажээ. Хоёрдугаарт орон нутгийн замын чанар муу, эрчим хүчний шугам хуучирч муудсан, агаарын тээврийн үйлчилгээ буурсан (ялангуяа баруун аймгуудад) зэрэг нь хүнсний бизнес эрхлэгчдэд ихээхэн саад тотгор болдог байна. Эцэст нь бизнес эрхлэгчид орц нийлүүлэлтийн (үйлдвэрлэлийн, санхүүгийн болон хүний нөөцийн) хувьд маш дутагдалтай байгаа нь бизнесийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах болон бизнесээ өргөжүүлэхэд саад тотгорыг учруулж байна.

<u>Хүнсний хангамж</u>

Өрхийн хүнсний баталгаат байдлыг тогтооход хүнсний хангамжийг тодорхойлох гурван бүлэг үзүүлэлтийг бидний зүгээс ашиглан Өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдал, хангамжийн харьцааг гаргахад зориулан цуглуулсан мэдээллээ боловсруулсан юм. Үүнд: хүнсний баталгаат байдалд хамаарах хувь хүний зан үйл, үйлдлийг нээн илрүүлэх болон өрхийн хүнсний баталгаат байдлын оноо зэрэг багтаж байна.

Хүснэгт 3: Сүүлийн 30 хоног дахь хүнсний баталгаат байдалд хамаарах зан үйл, үйлдлийг илрүүлэх (өрхийн аль нэгэн гишүүн)

	Жигнэсэн нийт дүн (%)
Гэр бүлийн хэмжээнд хангалттай хүрэлцэх хэмжээний хүнсний зүйл байхгүй хэмээн санаа зовних	26.1
Эх үүсвэрийн хомсдолтойн улмаас өөрийн дуртай хүнсний зүйлээ хэрэглэх боломжгүй байх	27.5
Эх үүсвэрийн хомсдолтойн улмаас цөөн тооны бүтээгдэхүүн хүнсэндээ хэрэглэх	19.8
Өөр бусад хүнсний зүйл худалдан авах эх үүсвэр дутагдалтайн улмаас өөрийн хүссэн хүнсний зүйлийг идэж чадахгүй байх	10.4
Хангалттай хэмжээний хүнс байгаагүйн улмаас өөрийн хэрэгцээнээс бага хэмжээний хоол идэх	14.3
Хүнсний зүйлс хомсоос хамааран өглөөний, өдрийн болон оройн хоолны аль нэгийг идэхгүй байх	10.9
Хүнсний зүйлс авах эх үүсвэргүйн улмаас өрхийн хэмжээнд ямар ч хоол идэхгүй байх	4.8
Хоол хүнс хүрэлцээгүй байснаас хамааран орой холо идэлгүйгээр унтах	5.5
Хоол хүнс хүрэлцээгүй улмаас юу ч идэлгүй бүтэн өдөр явах	2.9

(n=660)

Хүснэгт 3 нь эхний бүлэг буюу хүнсний баталгаат байдалд хамаарах хувь хүний зан үйлийг харуулж байгаа. Хүнсний баталгаат байдлын тал дээр хамгийн олон давтагдсан зан үйл болон үйлдэл нь ихэнх хүмүүс (нийт өрхийн 20-30%) өөрийн өрхийн хүнсний хангамжийн талаар ихээхэн дарамттай байж, үүний зэрэгцээ тэжээллэгийн чанарын хувьд санаа зовнидог болохыг харуулжээ. Зан үйлийн дараагийн олон давтамжтай хэсэг буюу нэг хүнд ногдох хүнсний хэмжээ багасах, зарим хоолоо идэлгүй өнгөрөөх зэрэг нь нийт өрхийн 10-15%-д ажиглагдсан байна. Эцэст нь нийт өрхийн 3-6% нь маш ноцтой хэмжээнд хүнсний баталгаат байдал нь алдагдаад байгаа бөгөөд өлсгөлөн байх, өрхийн хэмжээнд хүнсний хангамж маш муу байх зэрэг явдал тэмдэглэгдсэн байна. Улаангомын өрхүүдийн дунд хийсэн судалгаагаар дээр дурдсан 9 зан үйлийн 7 зан үйл нь хамгийн өндөр гарсан боловч энэхүү ялгаа нь статистик үзүүлэлтийн хувьд бусдаасаа хэт өндөр үзүүлэлт биш юм. Хамгийн ноцтой нь энэ аймгийн төвийн өрхүүд эх үүсвэрийн хомсдолоос шалтгаалаад идэх хоолгүй байх нь бараг 4 дахин их байлаа.[2]

Хоёрдахь үзүүлэлт буюу өрхийн хүнсний баталгаат байдлын онооны хүрээнд цуглуулсан мэдээллийг боловсруулан үр дүнг гаргасан. Өрхийн хүнсний баталгаат байдлын онооны хүрээний судалгааны асуултад өгсөн хариултуудын тооны дагуу өрхүүдийг хүнсний баталгаат байдал хангагдсан, бага хэмжээнд алдагдсан болон ноцтой хэмжээнд алдагдсан хэмээх гурван бүлэгт хуваасан юм. Нийтдээ бидний гаргасан дүн шинжилгээгээр аймгийн төвийн хүн амын гуравны нэг нь хүнсний хангамжийн баталгааны хувьд аюулгүй, харин ойролцоогоор 25% нь хүнсний баталгаат байдал бага хэмжээгээр болон ноцтой түвшинд алдагдсан болохыг тогтоосон (Хүснэгт 4). Аймгийн төвүүдийг харьцуулан үзвэл, Баруун-Урт хотын иргэдийн хүнсний баталгаат байдал ихээр алдагдсан байж болох ч үүний хэлбэлзлийн хэмжээ нь 10%-ийн түвшнээс хэтрээгүй юм.[3] Хүнсний баталгаат байдал алдагдсан өрхүүдийн дундаас Баруун-Урт хотын олон өрх бага хэмжээгээр болон ноцтой хэмжээнд алдагдсан байж болох бөгөөд харин Улаангом хотын өрхүүд нь бусад аймгийн төвүүдтэй харьцуулахад илүү ноцтой хэмжээнд хүнсний баталгаат байдал нь алдагдаад байна.[4]

[2] Жигнэсэн энгийн логик регресс загвар дээр хүнсэндээ хэрэглэх бүтээгдэхүүнгүй өрхийн Улаангом хотын хувьсагч нь = 3.835 (p<0.001).
[3] Жигнэсэн энгийн логик регресс загвар дээр хүнсэндээ хэрэглэх бүтээгдэхүүнгүй өрхийн Баруун-Урт хотын хувьсагч нь = 1.409 (p=0.071).
[4] Хүнсний баталгаат байдал ноцтой алдагдсаныг харуулах ижил төрлийн загварын Улаангомын хувсагчийн харьцаа = 2.240 (p=0.005).

Хүснэгт 4: Өрхийн хүнсний баталгаат байдал, хангамжийн ангилал (өрхийн тоо %)

	Жигнэсэн нийт дүн (%)
Хүнсний баталгаат байдал хангагдсан	67.2
Хүнсний баталгаат байдал бага хэмжэнд алдагдсан	10.7
Хүнсний баталгаат байдал их хэмжэнд алдагдсан	13.1
Хүнсний баталгаат байдал ноцтой хэмжээнд алдагдсан	9.1

(n=659)

Хүнсний хангамжийн гуравдах үзүүлэлт нь Өрхийн хүнсний баталгаат байдлын онооны аргаар тооцсон хүнсний баталгаат байдлын оноо байсан юм. Энэхүү үзүүлэлт нь нийт хүн амд 2.41-тэй байж Улаангом хотод хамгийн өндөр байсан ч бусдаас ялгарах зөрүү нь харьцангуй бага байсан юм. Судалгааны дүнгээр гарсанчлан хүнсний баталгаат байдлын дундаж оноо нь баталгаат байдлын алдагдалтай холбоотойгоор нэмэгдсэн. Өрхийн хүнсний баталгаат байдлын оноо нь шинээр гарсан үзүүлэлт тул энэ талаар хэвлэн нийтлэгдсэн зүйлс бага тул өөр бусад үзүүлэлтүүдтэй харьцуулан үзэх боломжгүй юм. Гэхдээ НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагийн судалгаа нь зарим талаар нарийвчилсан мэдээлэлийг өгөх боломжтой. Анхны судалгаагаар Мозамбикын төв хэсгийн ХДХВ/ДОХ-ын тархалт ихтэй нутагт хүнсний баталгаат байдлын дундаж оноо нь 10.6-14.4 хооронд байсан ба Буркина Фасо улсад хийсэн хоёрдахь судалгаа нь хүнсний баталгаат байдлын оноо 4.89-7.09 ийн хооронд хэлбэлзэж байгааг гарган ирсэн.

<u>Хангамж – Улирлын хэлбэлзэл</u>

Өрхийн хүнсний баталгаат байдлын үнэлгээний оноо болон тэжээллэгийн тархалтын онооноос гадна бидний ашигласан гуравдахь үзүүлэлт нь хүнсний баталгааны олдоцын тархалт байсан билээ. Энэхүү үзүүлэлт буюу Өрхийн хүнсний баталгаат хангамж бүхий сарууд хэмээх үзүүлэлт нь өрхийн хэмжээний хүнсний хангамжийн хамгийн ноцтой хүндрэл хэзээ гарсан болох, үүнийг улирал бүрээр хэлбэлзэлтэйгээр харуулдаг билээ. Судалгаанд хамрагдсан аймгуудын хувьд нийт өрхийн 23.6% нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд хүнсний хангамжтай холбоотой ямар нэгэн асуудалтай байна. Дунджаар эдгээр өрхүүд нь гурван сараас илүү хугацаагаар хүнсний хангамжийн доголдолтой байсан ажээ. Аймгийн төвүүдийн хооронд харьцуулан үзэхэд хүнсний хомсдолтой байсан өрхүүдийн дундаж тоо нь ялгаагүй байгаа ч хүнсний хангамжийн хомсдол нь баруун бүсийн аймгийн төвд харьцангуй удаан үргэлжилсэн байна.[5]

Хүснэгт 6: Өрхийн хүнсний баталгаат бүрэн хангамж алдагдсан сарууд

	Жигнэсэн нийт дүн
Сүүлийн 12 сарын хугацаанд дор хаяад нэг сарын туршид хүнсний хагамжийн доголдолтой байсан өрхүүд (%) (n=659)	23.6
Хангалттай хэмжэний хоол хүнстэй байгаагүй сарын тоо (Сүүлийн 12 сарын хугацаанд дор хаяад нэг сарын туршид хүнсний хагамжийн доголдолтой байсан өрхүүдийн дундаас) (мийн дундаж) (n=155)	3.11

(n=659)

Хүнсний баталгаат байдлын улирлын нөхцөл байдлын талаарх энэхүү үнэлэлтээр Монголын айл өрхүүд жил болгон тодорхой нэгэн цагт буюу 3-5 дугаар сарууд хүнсний хомсдлын асуудалтай тулгардаг байна. Гэхдээ энэхүү үнэлгээний хүрээнд гарсанаар хүнсний баталгаат байдалд үзүүлэх улирлын нөлөөлөл нь илүү өргөн хүрээнд байж болох ба үүнийг судалгаанд оролцогчдын хэлсэнчлэн өмнө дурдагсдан 3-5 дугаар сарууд болон үүнээс арай нөлөө бага 8 дугаар сард эхлээд 10-11 дүгээр сар хүртэл үргэлжилдэг өөр нэгэн хомсдол бас байдаг ажээ. (График 1).

[5] Хангалттай хэмжээний хүнсний хангамжгүй байсан сарууд жигнэсэн энгийн шугаман регресс загвар дээрх параметр нь баруун бүсийн ерөнхий хувьсагч = 0.26 (p=0.047)

График1: Хүнсний хангамж доголдож байгаа өрхүүдийн улирлын тархалт

(n=659)



Хангамж– Хооллолтын тархалт

Өрхийн хооллолтын тархалтын онооны модулийг ашиглан өрхийн хооллолтын тархалтын талаарх мэдээллийг цуглуулан авсан юм. Энэхүү үзүүлэлтийн хувьд оноо өндөр байх нь тухайн өрх нь хооллолтын тархалт өндөртэй, хүнсний баталгаатай болохыг харуулдаг билээ. Судалгаанд хамрагдсан өрхүүд нь нийт хүнсний 12 бүлгийн бүтээгдэхүүнээс сүүлийн 24 цагын хугацаанд дунджаар долоог нь хүнсэндээ хэрэглэсэн байлаа. Хамгийн олон удаа давтагдсан хүнсний зүйлсийн бүлэг нь үр тариа, мах, бусад (цай болон хачир зэрэг) болон тос/өөх зэрэг байв. Харин хамгийн цөөн дурдагдсан бүлэг нь өндөг, буурцаг/шош болон загас байсан юм. Судалгаанд хамрагдсан өрхийн 11% хүнсний бүтээгдэхүүний 5-аас доош бүлгийн бүтээгдэхүүнүүдийг хэрэглэсэн нь тэдний хооллолтын тархалт муу байгааг харуулсан. Иймт түвшний хооллолтын тархалт нь Мали улсад (6.1-6.7) тогтоогдсонтой ижил түвшинд бөгөөд харин энэ нь Азийн бусад орон болох Вьетнам болон Бангладеш зэрэг улсуудынхаас доогуур үзүүлэлт юм. Дээрх улсуудад мөн ижил төрлийн судалгааг яг ижил 12 бүлгийн хүнсний бүтээгдэхүүн дээр хийсэн бөгөөд тэдгээр улсуудын дундаж нь 8-9 байсан билээ. (Ходдинат болон Ёханесс 2002).

Хүснэгт 5: Өрхийн хооллолтын тархалтын оноо

	Жигнэсэн нийт дүн
Өрхийн хооллолтын тархалтын оноо (мийн)	6.85
Сүүлийн 24 цагийн дотор 5-аас доош бүлгийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэсэн өрхүүд (%)	10.8

(n=661)

Хүнсний хэрэглээ

5-аас доош насны хүүхдийн тэжээллэгийн нөхцөл байдлыг хүнсний баталгаат байдлын хэрэглээний тархалтыг харуулахад ашигласан болно. Баруун-Урт болон Арвайхээр хотуудын өрхийн эмнэлгээс цуглуулсан антрополог-хэмжээсийн мэдээллийн чанар муу байснаас хамааран зөвхөн Улаангом болон Ховдын (судалгааны баг нь антрополог-хэмжээсийн мэдээллийг өөрсдөө цуглуулсан) судалгааны дүгнэлтийг гаргасан болно.

Дээрх хоёр аймгийн төвийн хүүхдүүдийн дундаж жин нь биеийн жинг өндөрт харьцуулах Z онооны дундажаар 0.98 (хэвийн хэмжээнд) харин өндөрийг насанд харьцуулах Z онооны дундажаар-1.05 (бага зэрэг дутуу) болон жинг насанд харьцуулах Z онооны дундажаар 0.13 (хэвийн хэмжээнд) байна. Аймгийн төвүүдийн хоорондох энэхүү тэжээллэгийн индексийн хооронд ямар нэгэн их хэмжээний зөрүү илрээгүй. Судалгаанд хамрагдсан эмэгтэй хүүхдүүд нь ерөнхийдөө өндөр, жин хөнгөн байх нь ажиглагдсан ч өндөрийг насанд харьцуулах Z оноо ба жинг насанд харьцуулах Z онооны хувьд зөрүү нь өндөр биш нийт Z онооны бүрэлдхүүний хувьд ялгаа нь 10%-ийн түвшнээс илүүгүй байсан.[6]

График 2_{a-b}: Биеийн жинг өндөрт харьцуулах болон өндөрийг насанд харьцуулах Z онооны тархалт



(a) (b)

2a- 2b графикууд нь Улаангом болон Ховд хотын дээрх индексийн тархалтыг эрүүл хүн амын тархалттай харьцуулсан юм. Энэхүү харьцуулалтаар баруун бүсийн эдгээр аймгуудын төвийн хүүхдүүд нь байх ёстой хэмжээнээсээ намхан (График 2a) болон жин ихтэй (График 2b) байна. Нийтдээ хүүхдүүдийн 13.1% нь жингийн илүүдэлтэй, (WHZ > +2SD) болон 19.4% нь дутагдалтай, 10.7% нь их (HAZ < -2SD and >-3SD), 8.7% нь ноцтой хэмжээгээр жингийн дутагдалтай байна (HAZ < -3SD).

Хүснэгт 7: Дутуу болон илүүдэл тэжээллэгийг илрүүлэх нь (Улаангом, Ховд)

	Жигнэсэн нийт дүн
Жинг өндөрт харьцуулах (n=83)	
Бага зэрэг болон ноцтой хэмжээгээр жингийн дутагдалтай	-
Хэвийн жинтэй	86.7
Илүүдэл жинтэй	13.1
Өндөрийг насанд харьцуулах (n=83)	
Ноцтой хэмжээгээр жингийн дутагдалтай	8.7
Бага хэмжээгээр жингийн дутагдалтай	10.7
Хэвийн жинтэй	80.5
Жинг насанд харьцуулах (n=84)	
Их хэмжээний дутуу жинтэй	2.6
Бага зэрэг дутуу жинтэй	2.6
Хэвийн жинтэй	91.0
Илүүдэл жинтэй	3.9

Хүнсний баталгаат байдал алдагдсан өрхүүдийн шинж тэмдэг

Жигнэсэн тохиргоотой энгийн логик регрессийн загварчлалыг ашиглан, хүнсний баталгаат байдлын 4 хувьсагчийн (0,1) хоорондын холбоог тооцон гаргасан бөгөөд эдгээрээс гадна олон тооны бусад үзүүлэлтүүдийг судалсан юм. Хамгийн сонирхон судалсан 4 хувьсагч нь:

[6] [6] Жинг өндөрт харьцуулсан жигнэсэн энгийн шугаман регресс загвар дээрх параметр нь эмэгтэй хүүхдийн дундаж хувьсагч -0.340 (p=0.089)

өрхийн хүнсний баталгаат байдал алдагдсан эсэх (баталгаа бага, их, ноцтой хэмжээгээр алдагдсан), өрхийн хүнсний баталгаат байдал хэр алдагдсан (их, ноцтой хэмжээгээр), өрхийн хооллолтын тархалтын оноо нь 5-аас бага байсан болон сүүлийн 12 сарын туршид хүнсний хангалт муу байсан өрхүүд зэрэг багтана.

Хүнсний баталгаат байдлын хувьсагчуудтай хоёр бүлэг үзүүлэлтүүдийг харьцуулан үзсэн. Эхний бүлэг нь тухайн өрхийн шинж тэмдэгийн (жишээ нь өрхийн хэмжээ гэх мэт) талаар байсан. Энэхүү хувьсагчууд болон хүнсний баталгаат байдлын хоорондын хамаарлыг судлах болсон шалтгаан нь хүнсний баталгаат байдал алдагдсан өрхүүдийг тодорхойлох, тэдгээр өрхүүд нь хүнсний баталгаат байдал хангагдсан өрхүүдээс ямар ялгаатай болохыг тогтоох байсан. Хоёрдахь бүлгийн хувьсагчууд нь энэхүү судалгааны үзэл баримтлалын хүрээнд суурилсан хүнсний баталгаат байдал алдагдах үзүүлэлтүүдийг багтаасан. Үзүүлэлтүүд болон хувьсагчуудын хоорондын харьцааг дүгнэн шинжилснээр ямар шалтгааны улмаас өрхүүдийн хүнсний баталгаат байдал алдагдаж байгааг тогтоон, үүнийг бууруулах хөтөлбөр болон бодлогийн чиг баримжааг гарган ирж болно.

Хүснэгт 8: Хүнсний баталгаат байдал алдагдсан өрхүүдийн шинж тэмдэг – Энгийн логик регрессийн харьцаа

Хувьсагч	Өрхийн хүнсний баталгаа бага, их, ноцтой хэмжээгээр алдагдсан	Өрхийн хүнсний баталгаа их болон ноцтой хэмжээгээр алдагдсан	Өрх нь сүүлийн 24 цагын хугацаанд 5–аас доош бүлгийн хүнсний зүйл хоолондоо хэрэглэсэн	Сүүлийн 12 сарын туршид аль нэг сарын хугацаанд хүнсний хангамж хангалттай байгаагүй
Өрхийн хүнсний баталгаа бага, их, ноцтой хэмжээгээр алдагдсан			9.213***	15.661***
Өрхийн хүнсний баталгаа их болон ноцтой хэмжээгээр алдагдсан			7.074***	14.338***
Өрх нь сүүлийн 24 цагын хугацаанд 5–аас доош бүлгийн хүнсний зүйл хоолондоо хэрэглэсэн	9.213***	7.074***		5.135***
Сүүлийн 12 сарын туршид аль нэг сарын хугацаанд хүнсний хангамж хангалттай байгаагүй	15.661***	14.338***	5.135***	
Өрх толгойлсон эмэгтэй	1.522*	1.478	1.334	1.665**
Өрхийн гишүүдийн тоо	1.312***	1.322***	1.069	1.207***
Өрх нь найдвартай усны эх үүсвэр хэрэглэдэг	0.465	0.264***	0.236**	0.87
Өрх нь гэрт амьдардаг	1.893***	1.980***	3.142***	2.141***
Өнгөрсн жил ямар нэгэн хуримтлал үүсгэсэн эсэх	0.373***	0.179***	0.249***	0.302***
Өнгөрсөн жил ямар нэгэн зээл авсан эсэх	1.569**	1.489**	0.759	1.146
Өнгөрсөн сард ямар нэгэн орлого, тэтгэмж авсан эсэх	1.599	1.83	2.223	3.778**
Эзэмшиж буй нийт газрын хэмжээ (га)	0.370	0.464**	<0.001**	0.465
Өрхийн аль нэг гишүүд сүүлийн 15 хоногт өвчилсөн эсэх	1.664***	1.705***	1.624*	1.598***
Өрхийн нэг гишүүн нь өвдөж, эмнэлгийн тусламж авч чадаагүй эсэх	11.991***	15.219***	7.782***	3.164*
Нийт орлогийн тэтгэмжээс олдог хувь	2.202***	3.024***	3.167***	2.853***
Нийт орлогийн ажил эрхлэлтээс олдог хувь	0.464***	0.339***	0.311***	0.362***
Өрхөд байгаа жингийн алдагдалтай хүүхэд	11.268***	4.038***	0.895	4.802***

* p<0.10 ** p<0.05 *** p<0.01

Хүснэгт 8 нь хүнсний баталгаат байдлын хувьсагчийн энгийн логик регрессийн загварыг өрхийн шинж чанартай харьцуулсан дүнг харуулж байна. Хүнсний баталгаат байдал нь алдагдсан болох нь нэг хэмжээсээр гарч байгаа өрхүүд нь дараагийн өөр хэмжээсээр ч гэсэн

мөн л баталгаат байдал нь алдагдсан хэмээн гарах ихээхэн магадлалтай юм. Жишээ нь Өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдал, хангамжийн харьцаагаар хүнсний баталгаа алдагдсан хэмээн гарч буй өрх нь Өрхийн хүнсний баталгаат байдлын харьцаагаар алдагдсан хэмээн гарсан өрхөөс хооллолтын муу тархалттай хэмээн дүгнэгдэх боломж 9 дахин, сүүлийн жилийн турш хүнсний хангамж тааруу байсан хэмээн дүгнэгдэх боломж 16 дахин их байдаг. Хүнсний баталгаат байдал нь алдагдсан өрхүүдийн гол шинж нь Христын шашин шүтдэг, өрх толгойлсон эмэгтэй өрх, ам бүл олонтой, гэрт амьдардаг, өнгөрсөн жил зээл авсан, саяхан өрхийн нэг гишүүн нь өвчилсөн, эмнэлгийн тусламж авах боломжгүй, тэтгэмжид ихээр найдсан болон тэжээлийн дутагдалд орсон хүүхэдтэй өрхүүд байх болох магадлал өндөр байна. Хүнсний баталгаат байдал хангагдсан өрхүүд нь ихэнх тохиолдолд найдвартай эх үүсвэрээс ус авдаг, Буддын шашин шүтдэг, бусдад мөнгө зээлдүүлдэг, орлогынхоо дийлэнх хувийг ажил эрхлэлтээс олдог, өөрийн гэсэн газартай өрх байна.

Хүнсний баталгаат байдлын алдагдлын үзүүлэлтүүд

Хүснэгт 9 нь хүнсний баталгаат байдлын хувьсагчийн энгийн логик регрессийн загварын хувьсагчийг хүнсний баталгаат байдлын үзүүлэлтүүд хэмээн үзэж байгаа тэр үзүүлэлтүүдтэй харьцуулсан дүнг харуулж байна. Энэхүү дүн шинжилгээ нь 2 бүлэг үзүүлэлтүүдийг гаргасан ба үүнд хүнсний баталгаат байдлыг хангасан, болон хүнсний баталгаат байдлыг бууруулсан болон хүнсний баталгаат байдалд сайн ч, муу ч нөлөөгүй хэмээн ангилсан.

Ядуурал, ажилгүйдэл болон ажлын байрны баталгаа үгүй байх, сүүлийн үед үүсээд байгаа хүндрэл/хомсдол болон Баруун-Урт хотод амьдран сууж байгаа нь ч (зөвхөн 10%-ийн түвшинд) өөрөө айл өрхүүдийн хүнсний баталгаат байдал алдагдахад нөлөөлж байгаа билээ. Ядуурал болон ажилгүйдэл нь хүнсний баталгаат байдал алдагдахад хамгийн хүчтэй нөлөөтэй байна. Эдгээр нь хоёулаа хүнсний баталгаат байдлын бүх дөрвөн хувьсагчтай их хэмжээгээр хамааралтай байлаа. Ажлын байрны баталгаа байхгүй байх нь тухайн өрхийг бага, дунд болон их хэмжээгээр баталгаат байдлаа алдахад хүргэдэг бөгөөд сүүлийн жилүүдэд гарсан хүнсний хомсдолтой холбоотой байдаг ажээ. Гэхдээ энэхүү хувьсагч болон хооллолтын тархалтын эсвэл илүү ноцтой хэмжээний баталгаат байдлын алдагдлын хувьсагчийн хооронд ямар нэгэн их хэмжээний зөрүү гараагүй болно. Хүнсний баталгаат байдлын зөвхөн нэг хувьсагч буюу тухайн өрхийн баталгаат байдал бага, дунд болон их хэмжээгээр алдагдсан хэмээх хувьсагч нь саяхан болж өнгөрсөн хомсдол зэрэгтэй холбоотой байлаа.

Эцэст нь хэлэхэд өөр хоёр нэмэлт хүчин зүйл болох зээл авах болон өрх толгойлсон эмэгтэй бүхий гэр бүл гэсэн хоёр хүчин зүйл нь хүнсний баталгаат байдалд сөргөөр нөлөөлж болох тул энэ талаарх цаашид судлах шаардлагатай байна. Зарим талаар өнгөрсөн жилийн хугацаанд зээл авах болон хүнсний баталгаат байдал алдагдах хоёрын хоорондын харьцаа нь хүнсний баталгаат байдалд хамаатай нэгэн нөлөөллийг үзүүлж болох зөвхөн хэрэглээгээ хангах зорилгоор зээл авах явдал юм. Энэ шалтгааны улмаас, энэхүү хувьсагч нь хүнсний баталгаа алдагдсаныг харуулах шинж тэмдэгийг судлах хэсэг дээр багтсан юм. Гэхдээ зарим нотолгоогоор зээл авах нь хүнсний баталгаат байдал алдагдахад нөлөөлж, орлого нэмэгдэхэд ямар нэгэн нэмэр болдоггүй, эргэн төлөх нь өрхөөс зардлаа багасгаж, хэрэглээгээ бууруулахад хүргэдэг байна (Диагне1998).

Үүнтэй ижилээр, өрх толгойлсон эмэгтэй бүх өрх нь хүнсний баталгаат байдал алдагдсан байх нэг гол үзүүлэлт хэмээн эхэн үедээ тогтоосон байсан. Орлого, боловсрол, хүндрэл, ажил эрхлэлт, хөрөнгө зэрэг олон хувьсагчтай загварчлалд ороод ирэхээр өрх толгойлсон эмэгтэй нь хүнсний баталгаат байдал алдагдсан болохыг урьдчилан тогтоох нэг үзүүлэлт хэвээр байсан. Үүнээс үзэхэд эмэгтэй өрхийн тэргүүнтэй байх нь зөвхөн бага орлоготой гэсэн үг биш, мөн зээл авах боломж багатай, цөөн малтайг харуулж байгаа юм. Харин жендерийн

талаарх гол суурин энэхүү асуудал нь тухайн өрхүүдийн хүнсний баталгаат байдалд сөрөг нөлөөтэй болохыг харуулж байна.

Хүснэгт 9: Хүнсний баталгаат байдлын алдагдлын үзүүлэлтүүд – энгийн логик ргрессийн харьцаа

Хувьсагч	Өрхийн хүнсний баталгаат байдал бага хэмжээгээр буюу ноцтой хэмжээгээр алдагдсан	Өрхийн хүнсний баталгаат байдал ноцтой хэмжээгээр алдагдсан	Өрх нь сүүлийн 24 цагийн хугацаанд 5 аас доош нэр төрлийн хүнсний зүйлс хэрэглэсэн	Сүүлийн 12 сарын аль нэгд нь өрхийн хүнсний хангамж хангалтгүй байсан
Өрхийн тэргүүн өндөр түвшний боловсрол эзэмшсэн	0.864***	0.835***	0.723***	0.826**
2005 оноос хойш аймгийн төвд нүүж ирсэн	0.933	0.400	2.632	1.501
Өрх нь өөрийн малтай	0.622	0.640	0.53	0.976
Өрх нь бусдаар маллуулдаг өөрийн амины малтай	0.404***	0.330***	0.837	0.600**
Өрхийн тэргүүн нь ажил эрхлэгээгүй	2.824***	3.967***	4.139***	3.778***
Өрхийн хэмжээнд ажлын байрны баталгаа байхгүй	5.131***	2.108	3.012	4.841***
Сүүлийн сарын туршид хүлээн авсан тэтгэлэгийн хэмжээ (10,000)	0.972***	0.968***	0.968**	0.979**
Сүүлийн 6 сарын турш жимс, хүнсний ногоо тариалсан	0.965	0.964	0.202	0.590
Өрх нь сүүлийн үед хүнсний хангамжийн хүндрэлтэй тулгарсан	1.754**	1.39	1.734	1.476
Бүх эх үүсвэрээс орж ирэх нийт орлогийн хэмжээ (хүн тус бүрээр) (10,000)	0.842***	0.806***	0.790***	0.869***
Өрх нь ядуу өрхөд хамаардаг - < Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур	5.187***	4.897***	8.905***	4.138***
Өрх нь ядуу өрхөд хамаардаг – өдөрт 1 ам долларааас доош орлоготой	3.622***	4.372***	5.643***	3.650***
Өрх нь ядуу өрхөд хамаардаг – өдөрт 2 ам долларааас доош орлоготой	5.225***	5.011***	8.757***	4.365***

* p<0.10 ** p<0.05 *** p<0.01

Боловсрол, амины малтай байх, өндөр орлого болон орлогын хэмжээ нэмэгдэх зэрэг нь хүнсний баталгаат байдлын эмзэг байдлыг бууруулах гол хүчин зүйлс болж байна. Өндөр орлого болон орлогийн хэмжээ нэмэгдэх нь өрхүүд хүнсний баталгаат байдлаа алдах явдыг багасгаж энэ нь хүнсний баталгаат байдлын бүх 4 төрөлд мөн ижил хэмжээгээр хамаарч байна. Боловсролын хувьд ч гэсэн дээрхийн адил хэмжээнд байгаа бөгөөд өрхийн тэргүүний эзэмшсэн боловсролын аль нэгэн түвшин нь (жишээ нь дунд сургууль дүүргэсэн гэх мэт) хүнсний баталгаат байдал алдагдах нөхцлийг 15-28% хүртэл бууруулж чадаж байна. Эцэст нь хэлэхэд сүүлийн үед ихээр эрчимжиж байгаа суурин газар руу нүүх үзэгдэл болон жимс/ногооны үйлдвэрлэл нь дээр дурдагдсан 4 хувьсагчын альтай нь ч холбоогүй байсан юм.

Хэлэлцүүлэг

Хүнсний баталгаат байдлын нөхцөл байдал

Нийтэд нь дүгнэн хэлэхэд үнэлгээний үр дүнд анх удаа Монгол орны аймгуудын төвд оршин сууж буй иргэдийн хүнсний баталгаат байдлын талаарх тодорхой туршилтын, практик нотолгоог гаргасан билээ. Хэдий статистик үзүүлэлтээр Монгол улсыг бүхэлд нь хамарч чадахгүй ч, Баруун-Урт, Арвайхээр, Улаангом болон Ховд хотуудад хийсэн судалгааны үр дүн нь өөр бусад аймгийн төвүүдийн нөхцөл байдлыг ч мөн тусган харуулах боломжтой юм.

Хамгийн хүндрэлтэй зүйл нь хүнсний баталгаат байдлын хангамж, олдоцын асуудалтай хамааралтай байлаа. Өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдал, хангамжийн харьцаан дээр үндэслэн үзвэл, судалгаанд хамрагдсан өрхүүдийн гуравны нэг нь хүнсний баталгаат байдал нь алдагдсан, тэдний 25% нь хүнсний баталгаат байдал их хэмжээгээр алдагдсан нөхцөлд амьдарч байна. Өрхийн хоол тэжээлийн тархалтын оноо буюу хүнсний хангамжийн өөр нэгэн үзүүлэлтээс үзвэл нийт өрхийн 11% нь сүүлийн 24 цагийн туршид 4 болон түүнээс доош төрлийн хүнсний зүйлсийг хэрэглэсэн байна.[7] Үүн дээр нэмээд хүнсний баталгаат байдлын улирлын загварын асуудлаар цуглуулсан мэдээлэл нь хүнсний хангамж, ажлын байрны хэмжээ огцом буурдаг хаврын улиралд нөхцөл байдал ихээхэн хүндрэлтэй байдаг болохыг харуулсан юм.

Хүнсний баталгаат байдал алдагдсан өрхүүд нь ихэвчлэн ам бүл олонтой, гэр хорооололд амьдардаг болон төрөөс олгож буй мөнгөн тусламжаас ихээхэн хамааралтай өрхүүд байлаа. Энэхүү судалгаагаар илэрсэн хүнсний баталгаат байдал алдагдсан өрхүүдийн хамгийн гол үзүүлэлт нь ядуурал, ажилгүйдэл болон ажлын байрны баталгаа хомс байх зэрэг явдлууд байв. Өрх толгойлсон эмэгтэйчүүд болон авч буй зээлийг зөвхөн хэрэглээгээ нөхөхөд зарцуулж байгаа нь ихээхэн ноцтой асуудлууд байж болох юм.

Хүнсний бүтээгдэхүүний олдоц, хэрэглээ болон тогтвортой байдлын асуудлууд ч мөн аймгийн төвийн хэмжээний хүнсний баталгаат байдалд нөлөөлж байна. Хүнсний хангамж, олдоцын хувьд хүнсний үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн аймгийн төвийн хүнсний захуудаар жилийн туршид тогтмол хангамжтай байдаг ажээ. Гэсэн хэдий ч тодорхой нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний (жишээ нь мах, үйлдвэрлэл болон цагаан идээ) хувьд улирлын хэлбэлзэл өндөр байдаг ба энэ нь аймгийн төвийн оршин суугчдын хангамжид нийлүүлж буй хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, үнэд ихээхэн нөлөөлдөг байна. Энэхүү хангамжийн хэлбэлзэл дээр нэмээд орон нутгийн үйлдвэрлэл муу, захууд үйл ажиллагаагаа үр дүн муутай удирдан явуулдаг байдал нь ихээхэн нэрмээс болдог ажээ.

Хоол тэжээлийн асуудлаарх чанарын сайн мэдээллийг зөвхөн баруун аймгаас цуглуулсан нь хүнсний баталгаат байдлын хэрэглээний цар хүрээг тогтоон бий болгоход саад тотгор үзүүлсэн болохыг тэмдэглэж байна. Хэдий ийм төрлийн хязгаарлалтууд байсан ч бидний судалгааны дүн нь өмнө гарч байсан дүнгүүдтэй ижил хэмжээнд гарч баримжаагаар таваас доош насны хүүхдүүдийн 20% нь өсөлт удаантай байгааг тогтоосон юм. Мөн түүвэрлэн авсан хүүхдүдийн 13% нь жингийн илүүдэлтэй байсан нь (WHZ>+2- weight for height Z score буюу биеийн жинг биеийн өндөрт харьцуулсан оноо), Монгол улсын тэжээллэгийн асуудлаарх өөр бусад судалгаанд хамрагдаагүй хэдий ч хүүхдийн эрүүл мэндэд ихээхэн чухал нөлөөтэй асуудал байсан юм. Мэдээлэл цуглуулах, Мерси Корын ажилтнуудтай ярилцах болон өмнөх судалгаануудтай танилцах үед бидний ажигласанаар аймгийн төвийн хэмжээнд оршин буй тэжээлийн дутагдал нь голдуу үр дүн муутай хүүхдийн тэжээлийн аргачлал, өөх тосоор баялаг боловч хүний биед шаардлагатай бичил тэжээлийн бодисоор дутмаг орон нутгийн хооллолт болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын зүгээс хүүхдийн өсөлтийн монторингийг хангалтай түвшинд хийдэггүй зэрэг шалтгаанууд хослон үйлчилсэний үр дүнд үүссэн байж болох юм.

Эцэст нь хэлэхэд нийт өрхийн 13% нь сүүлийн үед ямар нэгэн байдлын хүнсний хангамжтай холбоотой асуудалтай тулгарсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь тухайн өрхүүдэд орлого буурах эсвэл тухайн хүндрэлээс үүдэх үр дагаварыг бууруулахын тулд нэмэгдэл зардал гарах зэрэг санхүүгийн сөрөг нөлөөллийг үзүүлсэн байна. Түүнчлэн гишүүд нь ажил эрхлэж буй өрхийн 6% нь өөрсдийн эрхлэж буй ажлаа баталгаатай ажлын байр хэмээн үзэхгүй байгаа ажээ. Нэгтгэн үзвэл, энэхүү судалгааны дүн нь өрхийн хүнсний баталгаат байдлын

[7] Хамгийн ихээр хоол тэжээлийн тархалт багатай өрхүүд нь будаа, мах, тос/өөх болон цай/хачир зэргийг хэрэглэсэн байна.

тогтвортой байдалд нөлөөлж болох өртөмтгий, эмзэг нөхцөл байдлын шинж, төрлүүдийг харуулж байна. Харин хүнсний баталгаат байдал нь ган, зуд зэрэг байгалийн гамшигтай шууд холбоотой хөдөөгийн иргэдтэй харьцуулахад аймгийн төвийн оршин суугчдын хүнсний баталгаат байдал нь харьцангүй сайн түвшинд байна.

Цаашдын үйл ажиллагаа

Аймгийн төвүүдэд хүнсний баталгаат байдал алдагдсан талаарх дээрх нотолгоо нь энэхүү тайланд дурдагдсан бусад үр дүнгийн хамтаар цаашид Монгол улсад хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд ихээхэн ач холбогдолтой юм. Доорх жагсаалтад аймгийн төвүүд дэхь хүнсний баталгаат байдлын асуудлаар холбогдон гүйцэтгэх боломжит үйл ажиллагааны жагсаалтыг гаргасан бөгөөд үүнд хоёр гол эхлэлийн цэгийг тогтоосон нь орон нутгийн хүсний зах зээлтэй холбоотой үйл ажиллагаа болон орлого багатай хөдөөгийн өрхүүдэд хүнсний баталгааг хангах явдал юм.

<u>Орон нутгийн хүнсний зах зээлтэй холбоотойгоор</u>

- ***Эрсдлийг бууруулсан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах*** – Бизнес эрхлэгчдийг малын индексжүүлсэн даатгал болон эрүүл мэндийн даатгал зэрэг эрсдлийг бууруулах үйлчилгээнд хамруулах нь хүнсний хангамж болон өрхийн хангамжид учирч байгаа аюулыг шийдэхэд өөрийн хувь нэмрээ оруулна.
- ***Сайжруулсан тээврийн системийг дэмжих*** – Энэхүү үнэлгээгээр аймгийн төвийн бизнес эрхлэгчдэд санаал болгож буй тээврийн үйлчилгээ, үүний тоо хэмжээ болон чанарын асуудалтай холбоотой олон асуудлыг гарган ирсэн бидээ. Энэхүү үнэлгээний үр дүн нь тээврийн үйлчилгээг сайжруулах хүчин чармайлт нь аймгийн хэмжээний бизнес эрхлэгчид болон хэрэглэгчдэд ихээхэн үр нөлөөг авчирж болох үйл ажиллагаа хэмээн тооцож байна.
- ***Орон нутгийн хүнсний үйлдвэрлэлийг орон нутгийн хэрэглээнд зориулах*** – Орон нутгийн хүнсний үйлдвэрийн асуудал дээр анхааран ажиллах нь орон нутгийн бизнес эрхлэгчдийн өрсөлдөх давуу талуудыг ашиглан бизнес эрхлэгчийг хүчирхэгжүүлэх, тэднийг сайжруулан, орон нутгийн зах зээл дээр хүнсний бүтээгдэхүүний үнийг бууруулах ач холбогдолтой.
- ***Худалдаачид болон жижиглэн худалдаачдыг хөтөлбөрт татан оруулах-*** Ихэнх тохиолдолд хөтөлбөрүүд нь хөдөөгийн үйлдвэрлэгчид зарим тохиолдолд хязгаарлагдмал хэмжээгээр боловсруулагчдад чиглэсэн байдаг. Гэхдээ хүнсний зах зээлийн хөгжлийг бүрэн хангахын тулд хөтөлбөрийн үйл ажиллагаа нь хүнсний өртгийн сүлжээний бусад оролцогчид болох худалдаачид болон жижиглэн худалдаачидтай мөн ажиллах шаардлагатай байна.
- ***Дэд бүтцийн хөгжил*** – Том хэмжээний бүтээн байгууллалтын төсөл нь ТББ-ын хөтөлбөрийн хүчин чадлаас хальж гарсан зүйл учраас үүний оронд жижиг хэмжээний дэд бүтцийг бий болгох үйл ажиллагаанд анхаарлаа хандуулахыг зөвлөж байна. Жишээ нь энгийн хйцтэй газар доорх зоорь болон дэвшилтэт хөргөлттэй агуулах зэрэг нь хөдөөгийн бизнес эрхлэгчдийн дунд ихээхэн эрэлттэй байгаа нь тогтоогдсон болно.

<u>Орлого багатай хөдөгийн иргэдийн хүнсний аюулгүй байдлыг хангахтай холботойгоор</u>

- ***Хуримтлалыг дэмжих*** - Өрхүүдэд хуримтлал үүсгэхийг дэмжсэнээр тэдний зээлээс хамааралтай байдлыг бууруулж, өрхүүд цаашид учирж болох хүндрэлд бэлтгэлтэй байх боломжийг бий болгоно.
- ***Мэргэжлийн сургалт*** – Мэргэжлийн сургалт, ялангуяа ажил олгогчидтой түншлэл тогтоон хийсэн сургалт нь аймгийн төвийн бизнес эрхлэгчдийн мэдэгдсэнээр хамгийн их эрэлттэй бөгөөд бизнес эрхлэгчид ч гэсэн өндөр чадвартай ажиллах хүчний дутагдалтай

байдаг байна. Гэхдээ одоогийн боловсролын байгууллагуудын чанарыг сайжруулах нь бүрэн хэмжээний сургалтын дараах ажлын сургалтын хөтөлбөрөөс илүү үр дүнтэй байдаг ба одоо үйл ажиллагиа явуулж буй сургуулиуд болон мэргэжлийн сургалт үйдвэрлэлийн төвүүдтэй хамтран ажиллах шинэ санаачлагийг гаргах шаардлагатай.

- ***Ажлын байр бий болгох санаачлага*** – Аймгийн төвийн хувьд хөдөлмөрийн эрэлтийг нэмэгдүүлж болох хоёр арга зам ажиглагдаж байна. Нэгдүгээрт зээл болон бизнесийн хөгжийн үйлчилгээгээр дамжуулан бизнес эрхлэх явдлыг дэмжих, ингэснээр шинээр бизнес, ажлын байр үүсэн бий болно. Хоёрдугаарт одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа бизнесүүдэд тулгарч байгаа гол саад тотгорууд нь зээлд хамрагдах боломж тааруу явдал тул дээр дурдагдсанчлан зах зээлийн илүү өргөн хүрээний асуудлуудад анхаарлаа хандуулан томоохон компаниудын зүгээс хөдөлмөр, ажиллах хүчний эрэлтийг үүсгэх, үүнийг дэмжин хөхүүлэх нь хамгийн зөв оновчтой арга зам байж болох юм.
- ***Хоол тэжээллэгийн талаарх мэдлэг/боловсрол болон өсөлтийн мониторингийг сайжруулах***
- ***Жендерийн асуудалд анхаарал хандуулах*** – Цаашид хүнсний баталгаат байдлыг сайжруулах талаар хийгдэх ямар нэгэн хөтөлбөрүүд нь өрх толгойлсон эмэгтэйчүүд болон хүнсний баталгаат байдал алдагдах явдлын харилцан дээр тулгуурлан үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна. Үүний боломжит сонголтууд нь өрх толгойлсон эмэгтэйчүүдэд болон эмэгтэйчүүдийн эрхлэж буй бизнесд үйл ажиллагааг чиглүүлэх, энэхүү харьцаа нь ямар шалтгааны улмаас үүсээд байгаа талаарх илүү их хэмжээний чанарын мэдэлээл цуглуулах үйл ажиллагааг дэмжих зэрэг байж болох юм.

Цаашид гүнзгийрүүлэн судлах салбар

Хүнсний баталгаат байдалд жендерийн эзлэх үүрэг, байр суурийг судлахаас гадна цаашид гүнзгий судалгаа хийн Монгол улсад хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг тогтоон, хэрэгжүүлэх боломж бүхий хэд хэдэн салбарууд мөн ажиглагдаж байгаа юм. Үүний хамгийн чухал ач холбогдолтой хэсэг нь зээлийн хэрэглээ бөгөөд үүний тоонд албан бус зээл авах явдал, зээлийн өрхийн зарлага болон хэрэглээнд нөлөөлөх үр нөлөөний талаарх судалгаа зэргийг багтаан гүнзийрүүлэн судлах шаардлагатай байна. Өөр бусад санхүүгийн бүтээгдэхүүнүүд болох хуримтлал/хадгаламж болон даатгал зэрэг нь зээлийн хэрэгцээг хэрхэн нөхөж болох талаар судалгаа явуулах нь ихээхэн сонирхолтой байх болно. Судалгаа явуулж болох бусад салбар нь хүнсний баталгаат байдлын салбар дахь улирлын хэлбэлзэл, тэжээллэгийн дутагдал болон үүний үзүүлэлтүүдийн талаар илүү нарийвчилсан мэдээлэл цуглуулах зэрэг байж болно.